

[ХҮНС] НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

БАТЛАВ: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ *Г.Улам-Өрнөх* Г.УЛАМ-ӨРНӨХ

[Цэцэрлэг]



[ ХООЛ ХҮНС] НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ

2024.02.02

**НЭГ. ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ХАРЬЦУУЛАЛТЫН  
ТЕНДЕРИЙН ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**Огноо:** 2024.02.02

**Тендер шалгаруулалтын нэр:** Цэцэрлэгт хүнсний материал нийлүүлэх тендер

**Тендер шалгаруулалтын дугаар:** ХЭАДЭСЦ/20240202001

**Санхүүжилтийн эх үүсвэр:** УРСГАЛ ТӨСӨВ

Дэлгэрхаан сумын цэцэрлэгийн Худалдан Авах Ажиллагааны хороо нь эрх бүхий тендерт оролцогчдоос “ХООЛ ХҮНС” барааг Тендер шалгаруулалтын онцгой журмын Харьцуулалтын аргаар үнийн саналыг Tender.gov.mn сайтад байршуулахыг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ХООЛ ХҮНС нь (СТАНДАРТЫН ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАСАН БОЛОН ТҮҮНТЭЙ ДҮЙЦЭХҮЙЦ БУСАД АЛЬ Ч УЛСЫН БАЙЖ БОЛНО) шаардлага хангасан байна.

Тендерийн үнийн саналыг 2024.02 сарын 16-ны өдрийн 10:00 цагаас өмнө Tender.gov.mn сайтаар орж явуулна уу. Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2024.02-16 ны 11:00 цагт нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг tender.gov.mn хаягаар авч болно.

ХЭНТИЙ АЙМАГ ДЭЛГЭРХААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГ

БАГШ Г.АМГАЛАН

ХАРИЛЦАХ УТАС: 91217305

**Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт** 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

**оролцогч ба эрх тухай** хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер **бүхий бараа** шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

**2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

**3. Тендерийн иж бүрдэл** 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) Үнийн санал;

(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;

(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (Сүүлийн нэг жилийн)

(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;

(д) ААНэгжийн гэрчилгээний хуулбар

/е/ [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан

- Бусад ААН, Албан байгууллагуудтай хамтран ажилласан 1 жилийн гэрээ

- Лавлагаа (Нийгмийн даатгал, Татвар, Банкны лавлагаа гэх мэт)

**4. Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

**5. Техникийн тодорхойлолт ба** 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах

арилжааны нөхцөлүүд үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

**6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## ТЕНДЕР шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнийн санал</li> <li>• Худалдаа эрхлэх зөвшөөрөл</li> <li>• Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>• Санхүүгийн тайлан: сүүлийн 1 жилээр /баталгаажсан/-хэдэн оны тайлан хэрэгтэй гэдгээ нарийвчлан зааж өгөх\</li> <li>• Чадварын мэдээлэл: сүүлийн 1 жилээр \бусад байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар\хэдэн он гэдгээ заавал зааж өгөх\</li> <li>• Хуулийн дагуу бүх татвар хураамжаа төлсөн тодорхойлолт</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>2024 оны 02 сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минут өмнө цахимаар хүлээн авна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Багш хөгжлийн төв Байгууллагын хаяг: Дэлгэрхаан сум 3-р баг байшин байр Давхар болон өрөөний дугаар: 2 давхарт багш хөгжлийн төв Огноо: 2024 оны 02 сарын 16-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p><b>ЭНЭХҮҮ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ НЬ:</b> <b>ДАРААХ НЭР, ДУГААР БҮХИЙ БАГЦААС БҮРДЭНЭ:</b> <b>Тендер шалгаруулалтын дугаар: ХЭАДЭСЦ/20240202001</b> <b>Нэр:</b> Хоол хүнс нь Улсын төсвөөс 2024 онд 54,312,900 төгрөг тогтоогдсон. <b>1. ХЭАДЭСЦ/20240202001 (1) дугаартай</b> Мах багц1 : 21,725,160 <b>2. ХЭАДЭСЦ/20240202001 (2) дугаартай</b> Хуурай хүнс багц2 : 32,587,900</p>

## **БАГЦ 2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:**

**ХЭАДЭСЦ/202402020012)** дугаартай **ХУУРАЙ ХҮНС\**

### **Барааны нэр: Гоймонгийн төрөл**

Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай

Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан, 200г-5кг-р савлагдсан, чийг аваагүй, хуурай, хөгцөрч муудаагүй, үйрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, урсамтгай биш шинж чанартай, 5-с доошгүй төрөл байна./шпагетти, дун, хөндий дүрс хэлбэрийн, туузан гэх мэт/, бэлэн бүтээгдэхүүн нь хаяг шошго сав баглаа боодолтой, монгол улсын стандартад нийцсэн байх

### **Барааны нэр: Будааны төрөл**

Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх шаардлагатай. Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн байх. /цагаан, хөц, гурвалжин, шар, хүүхдийн будаа\.. Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, Жнь: /сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай Цагаан будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцаахгүй, Хугацаа хэтрээгүй байх

### **Барааны нэр: Элсэн чихэр**

Бөөгнөрч барьцалдаагүй, гадны бохир биет байхгүй, монгол улсын стандартад нийцсэн, Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх ба Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн, Зориулалтын сав баглаа боодолтой, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

### **Барааны нэр: Гурил**

Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой байна. Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх шаардлагатай. Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн, Зориулалтын сав баглаа боодолтой байх, монгол улсын стандартад нийцсэн, гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй, 1-р зэргийн тэмдэгтэй, 25-50кг-аар савлагдсан, чийгээ алдаагүй, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

### **Барааны нэр: Давс**

Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой, Баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх ба Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн, Зориулалтын сав баглаа боодолтой, 0,5-1кг-аар савлагдсан, чийг аваагүй, хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж зохих түвшинд байх, гадны ямар нэг амт үнэргүй,

Монгол улсын стандартад нийцсэн, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

**Барааны нэр: Масло**

Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой, Баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх, Шошго, хаяг, нэр нь тод бүрэн байх, хайлаагүй, хөгцгүй, элдэв амт үнэргүй байх, Монгол улсын стандартад нийцсэн, улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

**Барааны нэр: Ургамлын тос**

Бараа бүрийн онцлогоос хамаарч сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн, Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байх ба Эрүүл ахуйн шаардлага хангасан элдэв өнгө, амт, үнэргүй, Монгол улсын стандартад нийцсэн байх

**Барааны нэр: Варень**

Бараа бүрийн онцлогоос хамаарч зориулалтын сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх ба Сав баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн, Монгол улсын стандартын шаардлага хангасан, Эрүүл ахуйн шаардлага хангасан, усжаагүй, хөгцгүй, элдэв өнгө, амт, үнэргүй, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

**Барааны нэр:Шинэ жимс**

/үзэм, чавга, алим, чацаргана гэх мэт/

Стандартын шаардлага хангасан, Зориулалтын сав баглаанд савласан сав нь гэмтэж хагараагүй байх ба Эрүүл ахуйн шаардлага хангасан элдэв өнгө, амт, үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо, чулуугүй, хог хаягдалгүй, Шинэ жимс нь исээгүй, няцраагүй, хорхой идээгүй, иш навчгүй, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

**Барааны нэр: Нарийн ногоо**

/Саримс, Ногоон сонгино,Чинжүү/

Стандартын шаардлага хангасан, Зориулалтын сав баглаанд савласан сав нь гэмтэж хагараагүй байх ба Эрүүл ахуйн шаардлага хангасан, үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх, ногоон сонгино 20 гр аас багагүй байна. чинжүү 4-5см диаметртэй бяцарч гэмтээгүй, болц гүйцсэн, хөлдөөгүй байна.

**Барааны нэр: Бусад хүнс**

Бараа бүрийн онцлогоос хамаарч зориулалтын сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх шаардлагатай, баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн байх

- Исгэгч
- Хуурай цай/гүрж ногоон цай/
- Цайны печень

Эрүүл ахуйн шаардлага хангасан элдэв хөгц амтгүй, Монгол улсын стандартад нийцсэн Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Гоймон	Макбур 1уут нь 5кг- тай	<b>ХЭАДЭСЦ/20240202001 (2)</b>	75	кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
	А/Тариа\ Лапша 1 уут нь 3кг - тай		51				
	Шпагетти						
Будаа	Цагаан будаа		500	кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
	Хөц будаа		57	кг			
	Гурвалжин		25	кг			
	Шар будаа		80	кг			
	Хүүхдийн будаа		137	кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Элсэн чихэр			640	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Гурил			2500	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Давс		93	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	



[ХҮНС] НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Ургамалын тос /sunny gold/		164	Л	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Масло		137	Л	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Варень		130	Ш	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Үзэм		30	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Чацаргана		100	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Түргэн эсгэгч 10гр		2.5	кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Хуурай цай \ том\		6	Ш	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Саримс		18	кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Ногоон сонгино 10 гр		376	Ш	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар
Чинжүү		91.5	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар

## ХҮНСНИЙ НОГОО

### Хүнсний ногоонд тавигдах ерөнхий шаардлага:

Нийлүүлэгдэх ногоо нь монголд тариалагдсан, стандартын шаардлага хангасан, ялзарч муудаагүй, зөөлрөөгүй, соёолж хөгшрөөгүй, хайрагдаагүй, хөгцрөөгүй, чийгээ алдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй, шинэ, гадаргуунд нь шороо чулуу наалдаагүй байх/

#### Барааны нэр: Төмс

Төмсний диаметр 6-7 багагүй, 1ш төмсний дундаж жин 180-250гр, Хорхойд идэгдээгүй байх

#### Барааны нэр: Байцаа

Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй, дундаж жин нь 2-2,5кг, Гадаргууны илүүдэл хатсан навч голыг цэвэрлэсэн байх

#### Барааны нэр: Бөөрөнхий сонгино,

Ааг амт сайтай, 100кг сонгино бүрт 2кг хорогдол тооцож байх түүнтэй тэнцэх хэмжээний сонгино нэмж нийлүүлэх

#### Барааны нэр: Лууван

Луувангийн дундаж жин 200-300гр, Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай, улбар шар өнгөтэй, 100кг лууван бүрт 2кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж нийлүүлэх

#### Барааны нэр: Манжин

Гадаргууны шороо, үндэс навчийг бүрэн цэвэрлэсэн, муудаж гэмтээгүй байх

## БАРААНЫ ЖАГСААЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмж их нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Төмс	Багц 2: ХЭАДЭСЦ/20240202001 (2)	1230	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Байцаа		660	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Сонгино		360	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Лууван		356	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Манжин		354	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	

**БАРААНЫ НЭР:** Талх

Хэлбэр дүрсээ алдаагүй, өнгө үзэмж сайтай, хөгцрөөгүй, шинэ байх ба Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн амин дэм ккал нь стандартын норм хангасан эрүүл хүнс байх

**БАРААНЫ НЭР:** ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН

Бараа бүрийн онцлогоос хамаарч зориулалтын сав баглаа боодолтой, Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх шаардлагатай, баглаа боодлын шошго, хаяг, нэр нь тод бүрэн байх

- Зүсмэл
- Мөөхий
- Зочин
- Цайны боов

Эрүүл ахуйн шаардлага хангасан элдэв хөгц амтгүй, Монгол улсын стандартад нийцсэн, Үйлдвэрлэгдсэн улс нь тодорхой, сав баглаа боодол дээрх нэр шошго нь тодорхой гаргацтай байх

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Өгөөж боов	Багц2 ХЭАДЭСЦ/20240 202001 (2)	200	уут	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	

**. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ: ХЭАДЭСЦ/20240202001-2 дугаартай / СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН/**

**Ерөнхий зүйл:** Нийлүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь монгол улсын стандартын шаардлага хангасан, эх орны бүтээгдэхүүн байх

**Барааны нэр: Шингэн сүү**

Нийлүүлэгдэх сүү сүүн бүтээгдэхүүн нь монгол улсын бүтээгдэхүүн, Эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын саванд савлагдсан байх ба Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх, шинэ, шингэн хугацаа хэтрээгүй байна. Тээвэрлэлт, хадгалалтийн горимыг баримтлах

**Барааны нэр: Аарц**

Цагаан өнгөтэй, Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан, Хэт исгэлэн, гашуун, ахарсан, хөгцөрсөн биш, Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд байх ба Хадгалалтын горимыг хангасан, хог, чулуу шороо, хялгасгүй байна.

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

1	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
2	3	4	5	6	7	8	
Шингэн үнээний сүү	Багц 4 ХЭАДЭСЦ/202301009(4)		Л	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Үйлдвэрийн савтай сүү /1л/		754	Л	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Аарц		400	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	

### Багц 1 . ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

#### ХЭАДЭСЦ/202402001-1 дугаартай МАХ

**Барааны тодорхойлолт:** Махны стандарт нь шаардлага хангасан мах нь шинэ чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэсэн, гадаргуу цэвэр, гадны үнэр, амтгүй, шивтэр, бензин гэх мэт, хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүнгүй, 1-р зэргийн үхэр болон хонины мах байх ба Үхрийн мах нь 120кг-аас дээш жинтэй, хонины мах 20 кг –аас дээш жинтэй байна. Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцна. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.Махыг хүргэж ирэхдээ гадны бохир биетээс тусгаарлаж цэвэр баглаа боодолтой хүргэж ирнэ.

## Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон
1	2	3	4	5	6	7	8
Үхрийн мах	Багц 5 ХЭАДЭСЦ/202301009(5)	2000	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	
Хонины мах		1000	Кг	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	2024.01 сар	2024.12 сар	

## Дөрөв: 1.ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. Өмнө болон Одоо хэрэгжиж буй гэрээ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				



[ХҮНС] НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

3.				
4.				
5.				
бусад.				

**Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Шалгалт туршилтыг нийлүүлэгчийн газарт явуулсан бол Захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана. |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.  |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотерм (NCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаа оловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.   |
| <b>5. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 5.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.  |
| <b>6. Төлбөр</b>  | 6.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 1 сарын дотор шуурхай хийнэ.  |
| <b>7. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 7.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө   |
| <b>8. Алданги оногдуулах</b>                              | 8.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэж чилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэгийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжэгрэхгүй.   |
| <b>9. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>          | 9.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |

- 10.**Маргаан ыг шийдвэрлэх  
10.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана
- 11.**Маргаан ыг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1 5 багцад багтсан хүнсэнд техникийн тодорхойлолтонд тусгагдсан чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нярав болон бусад эрх бүхий хүмүүс байнга шалгаж байна. Нийлүүлэх барааны онцлогоос шалтгаалан агуулахад хүлээж авахад техникийн тодорхойлолт хангаж буй хэсгийг баталгаажуулах зорилгоор нярав, тогооч хяналт тавьж хүлээн авна.
- 1.1. Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, нэр хаяг шошго нь тод бүрэн байх
- 1.2. Хүнсний бүтээгдэхүүн нь монгол улсын стандартад нийцсэн, хадгалалтын хугацаа байна
- 1.3. Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцах /төлбөр төлөх/
- 1.4. Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар няравын захиалгын дагуу тухай бүрд нь хүргэж ирнэ.
- 1.5. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Нэхэмжлэх ,зарлагын баримт
  - 2) Тухайн жилийн шинжилгээний бичиг
  - 3) Мах нийлүүлэх бүрдээ шижилгээний бичигтэй ирэх
  - 4) Гарал үүслийн бичиг
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Бараа нийлүүлэх хуваарь
- 3.1. Тухайн үеийн хүүхдийн ирцээс шалтгаалж нийлүүлэлтийн хуваарьт өөрчлөлт орж болно
4. Төлбөр (ГЕН – 7)
- 3.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийн барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги  
оногдуулах  
(ГЕН - 9)<sup>1</sup>

Санхүүжилтийг төсвийн хуваариар хийхээс өөр боломжгүй тул алданги тооцохгүй байх ба бусад нийлүүлэгчээс авсан бараа сарын төсвийн хуваариас хэтрэхгүй байна.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]